

ХОРЧИНЫ “ГАЛАВЫН ҮЛГЭР” ДЭХ ДОМОГ ЗҮЙН ДҮР, ӨГҮҮЛЭМЖ

Г.Нандинбилиг

Түлхүүр үг: *Монгол домог зүй, баатарлаг туульс, Галавын үлгэр, мангасын үлгэр, хорчины соёл, хуурч, цоорч*

Энэхүү өгүүлэлдээ бид хорчин монголчуудын дунд “Галавын үлгэр” хэмээх нэрээр уламжлан ирсэн монгол домог зүйн уламжлалын дүр, өгүүлэмж хийгээд төрөл зүйлийн асуудлаар санал хуваалцахыг зорьсон болно.

“Галавын үлгэр” хэмээх энэ домог зүйн бичвэрийг анх 1977 онд МУИС-ийн профессор С.Дулам хорчин монголын Сүргийн хошуунаас 1940-өөд оны үед Улаанбаатар хотод нүүж ирсэн Баярын Чунраа өвгөнөөс тэмдэглэн авч, 1982 онд орос орчуулгыг өөрийн дэд эрдэмтний диссертацийнхаа хавсралтад (1982:150-217) оруулж танилцуулаад, удалгүй 1983 онд жинхэнэ эрдэм шинжилгээний хэвлэлийг Прагийн их сургуулийн Дорно дахины судлалын цувралаар англи орчуулгын хамт Я.Вацектай хамтран хэвлүүлсэн байна. “A Mongolian mythological text” (Монгол домог зүйн бичвэр) нэрээр гарсан анхны хэвлэлд “Галавын үлгэр” бүтээлийг эрдэм шинжилгээний галиг үсгээр буулгаж, судалгааны удиртгал, тайлбар, англи орчуулгын хамт гаргасан бол хожим 2013 онд Б.Чунраа гуайн фото зураг, товч намтрыг номд нэмж дахин хэвлүүлжээ.

“Галавын үлгэр”-ийг хэл бичгийн шинжлэх ухаан болон эх бичгийн судлалын өндөр түвшинд бэлтгэн гаргасан бичвэр ийнхүү судалгааны эргэлтэнд орсноор Германы эрдэмтэн В.Хайссиг, Оросын эрдэмтэн В.Э.Раднаев, С.Ю.Неклюдов, БНХАУ-ын Бээжингийн их сургуулийн профессор Дулаан нарын эрдэмтэд судалсан байна.

Анх Оросын эрдэмтэн С.Ю.Неклюдов 1984 онд “Монголын баатарлаг тууль” номдоо тус бичвэрийг домог- тууль гэсэн нийлэг нэр томъёогоор тодорхойлоод, баатруудын нэг болох мангасын охин Галвин Сөөрийн дүрийг Гэсэрийн туужийн хорчин, жаруудын хувилбарын мангасын охин Гялбан шартай харьцуулаад, энэ хоёр бүтээл шууд холбоотой болохыг тодруулсан бол 1988 онд Германы эрдэмтэн В.Хайссиг хожуу үеийн монголын баатарлаг туулийн хүүрнэлийн судалгааны тулгуур бүтээлдээ Галавын үлгэрийн тус бичвэрийг зүүн монголын туульсын хүрээнд авч үзэн, гүнзгий судалсан байна. Мөн 1999 онд С.Ю.Неклюдов тус Галавын үлгэр болоод зүүн монголын үлгэрлэг туулийг хооронд зэрэгцүүлж судлаад, “Монгол туульсын баатар зорьсон газраа хүрч ирээд сүйт бүсгүйн аав болон ах нь охиныг өгөхгүй гэхэд тулалдаж дийлээд, охиныг булаан авч буцдаг бол Галавын үлгэрт мангасын хүүд амалсан Умард шамбалын орны гүнжийг авч харьж байна. Мангасын орон луу аянд гарсан баатруудын өмнөөс мангасын үзэшгүй муухай охин тосон ирж байгаа өгүүлэмж бас энэ Галавын үлгэрт Алвин Сөөрий гэж шулмын дүрээр мөн дүрслэгдэж байна. Өгүүлэмжийн энэ их олон төсөөтэй үйл явдлууд юуг харуулж байна вэ гэхээр энэ Галавын үлгэр гэдэг домог- тууль нь зүүн монголын уламжлалаас хожуу хөвөрч гарсан, бусад үлгэр туультай нэгэн эх сурвалжтай юм гэдгийг харуулаад байна” (1999:101) гэж дүгнэж байжээ.

С.Дуламын хэвлүүлсэн “Галавын үлгэр” бол 60 орчим хуудас хэмжээтэй, С.Ю.Неклюдовын тооцоогоор, яарамгүй ярихад бол 3 цагаас наашгүй гэж хэлэхээр, өдөр бүр 2-3 цаг хайлахад бол 7 хоног элбэг болно гэж бодоод ойролцоогоор тооцоолбол 15000 мөр туульсын шүлэг болохоор хүүрнэн өгүүлсэн бүтээл юм. Харин 2019 оны 8 сард БНХАУ-ын Тунлио хотод “Хуурын үлгэр”-ийг судлах олон улсын эрдэм шинжилгээний хуралд очих үедээ бид Галавын үлгэрийг өвлөн тээгч, үлгэрч, хуурч С.Жалсантай¹ уулзан сурвалжилснаар тус бичвэр нь арван хэдэн бүлгээр хэлэгдэх, хэмжээний хувьд үлэмж домог зүйн нэгээхэн хэсэг болохыг мэдсэн юм. Хуурч С.Жалсан гуай бидэнд “Энэ бол шүлэгчилсэн үлгэр шүү. Алга дэлгэвэл тарни, амаа хөдөлгөвөл шүлэг болно” гээд “Бага зургаан галав”, “Их арван найман галав”, нийт хорин дөрвөн галав хэлэлцдэг болохыг мэдээлсэн юм. үүнд:

А. Их арван найман галавт

1. Боди галав
2. Алтан галав
3. Догшин билигт галав
4. Аварга чулуун баатар галав
5. Агжа баатар галав
6. Чимиддорж галав
7. Өвгөн бохир галав
8. Хүрэлбаатар галав
9. Шаргалдай мэргэн галав
10. Найжи тэнгэр галав
11. Ниснаа галзуу галав
12. Сүртү галзуу галав
13. Очи тэнгэр галав
14. Гунан хар галав
15. Дугуй хар галав
16. Алтан бор морь галав
17. Зөн билигт галав
18. Хөх бух галав

Б. Бага зургаан галавт

1. Маасгал хатан галав
2. Хайл мэргэн галав
3. Гялар шар хатан галав
4. Үүлэн түмэн сандал
5. Эзэн түмэн сандал галав
6. Мөст хатан галав зэрэг болно.

Жалсан хуурчийн ярьснаар, “Энэ галав мянган галав, сайн цагийн мянган мянган бурхан. Хамаг сүүлд догшин галав Дүйнхорын галав. Отгон галав дээр ирвэл шувуу шаазгай үг хэлнэ, хүнд муу сэтгэл үгүй болно, амьтан бүгд бурхан болно. Одоо бидний энэ галав Шагжамунийн галав бол тав дахь галав. Анхдугаар галав Аюуш Майдар салхиар юүлж, хоёр дахь Хончингавха аянгаар юүлж, гурав дахь Гаагшвын галав галаар юүлж, нүүрс гэдэг галаар юүлснийх, дөрөв дэх Дэмчигийн галав усаар юүлжээ. Дэмчигийн галав юүлэхдээ хоёр зуун жил бороо орж, Сүмбэр уулын тогоон чинээ газар үлдээд, бүгд ус болжээ. Багш Гариваа Гагиваа хоёр шавиа дагуулж ирж. Дэлхий дээр уснаас өөр юмгүй байж. Нэг нь зүүн тэнгэрт яв, нөгөө нь баруун тэнгэрт яв гээд, нэгэнд нь хумх өгч, үүнийг дүүргээд ир гэж, нөгөөд нь мөнхийн эрдэнэ авчир гэжээ. Мянган өдрийн номд суухад ус сууж, Сүмбэр уул дунд чинээнээс ил гарчээ. Найман

¹ Сэржээхорлоогийн Жалсан - 1950 онд төрсөн, цагаан бар жилтэй, Тунлио найман хошуу, урианхай аймгийн хүн. БНХАУ-ын Тунлио хотод МУИС-ийн проф Г.Нандинбилиг, С.Дулам нар 2019 оны 8 сарын 28-30 өдрүүдэд түүнтэй уулзаж, Галавын үлгэрийн уламжлалаас сурвалжлав.

эрдэнийн нуур авчруулжээ. Тэр хумхыг дүүргэж авчир, зүүн тэнгэрийн мөнх голоос хумх авчир. Энэ авчирсан шавраараа хүн барина гэж. Тэгээд хар толгойт мянган хүн, мянган эхнэр барьж. Арга билгээр бурхан бүтээж, мянган өдрийн номонд сууж. Мангасын үлгэр ингээс эхэлнэ”. Өөрөөр хэлбэл, Галавын үлгэр нь галав үүсгээд, хүн үүсгээд эхлэх ажээ.

Жалсан хуурч энэ уламжлалыг 1970-аад оны үед Бо. Намжил гэж хүнээс сурсан гэнэ. Тэрээр бидэнд хуучлахдаа, “Миний ээж хуур татна. Би багаас хуур татах дуртай, 16 наснаас хуур татсан. Би 22- тойдоо аавгүй болжээ. Усан цөөрөм байгуулж хөдөө яваад, уушигны өвчин олжээ. Тэгээд хуур татсан. Би 25 настай Жирэм аймагт иржээ. Бо. Намжил гэж хүнээс модон цоор татаж сурчээ /Сүүдрийг харуулав/. Тэр мангасын үлгэр хэлэхэд би их сонирхож. Тэр өөрийн багшаасаа суржээ. Тэгтэл намайг чи миний гэрт очоод, нэг гариг сурч болно гэж. Тэр цагт дэнхуа үгүй ээ. Тэр хүн Тангаргын сүмд суужээ. Дархан хошуунд тийм сүм байжээ. Намжил лам унзад лам эрхэлж байжээ. 27 настай би эрж очжээ. Тэр Хүйтэн зуу гэсэн газар байжээ. Гагцаараа нэг багахан гэрт сууна, ядуу гэж. Намайг очихоор цонхоо бүрхээд заана. Тэднийд нэг сар сууж, тэр ардын дуу нэн арвин мэднэ. 18 их галав, бага галав 6, нийт 24 галав сурж. Цоороор аажуу дуулна. Энэ хүн мэдэхгүй юмгүй. Би гурван жил өнгөрөөд, нас гуч гараад бас очсон. Тэгэхэд “Чи үнэн санаагаар иржээ. Чи суръя гэвэл сур. Би өтөлжээ” гэсэн. Би сураад хаячиж, бичиж авсан нь байна. Тэр үед мангасын үлгэрийг хүн хүндэтгэхгүй, сонсох хүн үгүй ээ, хүмүүс хуурын үлгэрээ л сонсоно” гэхчлэн ярьсан юм.

Жалсан гуай Бо Намжилаас анх үлгэрийг сурсан ч мартагнаж байгаад, сүүлд Намжилын зээ Бүрэнцуглаас Галбын үлгэрийг сүүлд сэлбэж сэргээн авсан бололтой. С.Жалсан хуурчийн талаар бидэнд мэдээлсэн ӨМҮИС-ийн багш Буянтогтохын мэдээлснээр, Бо. Намжил нь боржгин хүн бөгөөд Дархан хошууны лам хүн байжээ. 1910-аад онд төрөөд, ная гаруй насандаа 1995 онд нас баржээ. Найман хошууны сүм дээр байсан Тогтох гэж лам багшаас шашны мэдлэг олсон ба тэрээр Галавын үлгэрийг Жалсан гуайгаас гадна өөрийн зээ Бүрэнцуглаад уламжлуулан үлдээсэн ажээ. Бо. Намжилын зээ Бүрэнцуглаа албан ажлаас амарч сууснаар Галавын үлгэрээ хэлж, сүүлийн таван жилээс энэ уламжлал дахин сэргэж байгаа ажээ.

1977 онд Б.Чунраа өвгөний хэлсэн Галавын үлгэрийн бичвэрийг задлан шинжилж үзвэл, эхлэл хэсэгт газар тэнгэр үүсэхийн өмнө Тэнгэр нарын чуулганаас Шагжамунийг энэ Галавын эзнээр томилсон тухай, Шагжамуни бурхан нэлий их усан дундаас газар дэлхийг үүсгэсэн тухай, аварга мэлхийг харваж, таван зүг, таван махбод бүрэлдсэн тухай, анхны хүмүүс хийгээд нар, сар, одон мичид хэрхэн үүссэн тухай өгүүлнэ. Гэхдээ бичвэрийн эхлэл хэсэг бол маргаангүй домог зүйн шинжтэй юм. Энд эмх замбараагүй \усан\ дундаас газар дэлхий хэрхэн үүссэн тухай, аварга матар мэлхийг харваснаар газар дэлхийн таван зүг, таван махбод бүрэлдсэн тухай, тэнгэрээс арван найман эрэгтэй, найман эмэгтэй хүн өгч, хүний омгийг үүсгэсэн тухай хийгээд нар, сар, одон мичид хэрхэн үүссэн тухай анхан туурвилын домгууд гардаг. Судлаачид тус бичвэрийг янз бүрийн домог зүйн эх сурвалжаас зүйж нааж тайлбарлах гээд байдаг ч энэ домогзүйн өгүүлэмж нь өөрөө салгахад түвэгтэй нэгдмэл цул бүтэц байгаа бөгөөд тэр дундаа матар мэлхийг харвах өгүүлэмж хийгээд газар дэлхий биежих өгүүлэмж бол монголын домог зүйн өгүүлэмж байна. Шууд хэлэхэд, эдгээр анхан туурвилын домгууд ийм бүхэл цогцолбор байдлаар өнөөг хүртэл олдоогүй байсан билээ. Урьд өмнө нь хэсэг бусад байдлаар тохиолдож байсан монгол домог зүйн өгүүлэмжүүд энд ийм нэгэн бүхэл цогцолбор байдлаар оршиж байгаа нь ямар үнэ цэнтэй вэ? Энэ тухайд С.Ю.Неклюдов “...нэг талаас нь Төв Азийн ардын буддизмын мотив дээр үндэлсэн ертөнцийн болон хүний үүслийн домгоор хашлага хийж, нөгөө талаас нь Гэсэр мэндлэхийн өмнөх түүхийн угсаа гарлын домгоор хашлага хийсэн байна. Энэ хашлага нь хэдийгээр хэмжээ нь бага ч гэсэн утгын даац нь бол үндсэн туулийн хүүрнэлээсээ чухал ч байж мэднэ” хэмээн үнэлсэн байдаг.

Галавын үлгэрийн үйл явдал буюу үндсэн өгүүлэгдэхүүн нь газар дэлхий дээр мангас махчид дураар дургиж, хүн зоныг барьж идэн, хүний омгийн гуравны нэгийг устгасан тухай,

тэнгэрийн эзэн Хурмаст тэнгэр их чуулган чуулж, хүний ертөнцийг тохинуулахаар тэнгэрийн баатар, дагинасуудыг газарт буулгахаар тушаасан тухай, тэнгэрээс эхлээд долоо, сүүлд хоёр, нийлээд есөн тэнгэр газарт бууж мэндэлсэн тухай, эхний долоон тэнгэрийн дөрөв нь хүний төрөлд, гурав нь мангасын хүчийг авахын тулд мангасын төрөлд төрсөн тухай, тэгээд тэнгэр нар он удаан жил газар дэлхий дээр хэцүү хатуу тэмцэл тулаан хийж, мангасыг дараад, газар дэлхийг тохинуулаад буцсан тухай өгүүлнэ.

“Галавын үлгэр”-ийн орон, цаг хийгээд дүрүүд нь домгийн далд санаагаа тодруулна. Цагийн хувьд авч хэлбэл, ертөнц үүссэн анхан эрт цагт өсөж үржиж байсан хүний омгийн хагасыг шахам залгиж орхисон махчин мангасын цаг буюу хүн хүнээ барьж идэж байсан аймшигт цаг үеийг тусган өгүүлнэ. Жишээлбэл, *“Хэдэн жил хүний омог үржиж, уул устай болоод хүний тоо гурван мянгад хүрч байсан, хожмоо нэг үзэхнээ хоёр мянга болж цөөрөөд, нэг мянган хүн нь алга гэнэ. Яав ийв гэсэн, мангас идээд цөөрчихсөн байна гэнэ”* гэж гардаг. Домгийн энэ цаг үед газар дэлхий дээр малын мах иддэг нэгэн омог улс, ургамал жимс иддэг нэгэн омог улс, хүний мах иддэг мангасууд зэрэгцэн амьдарч байна. Тэгээд тэдгээр мангасыг дарахын тулд тэнгэрт чуулган чуулж, Хурмаст тэнгэрийн тушаалаар газарт есөн тэнгэр, дагинас бууж ирэхээр болно. Тэнгэр нар бууж ирэхдээ дөрөв нь малын мах иддэг хүний омогт төрж, гурав нь мангасын хүч чадлыг нь авахын тулд хүний мах иддэг мангаст хувилж мэндэлнэ. Эхлээд Алтангалав Сандал хаан гал хот мандалтайгаа малын мах иддэг хүний омогт бууна. Мөн Алтан дуулга нэрт баяныд хар царайт Хар сандал баатар, цагаан царайт Цагаан сандал баатар, Түвдэннимаа Осормаа гурав хүнд хувилж төрнө. Харин Шилэн галзуу баатар, Суунаг цагаан баатар, Сам бурхан гурав мангаст хувилж төрнө.

Б.Чунраагийн мэдээлсэн “Галавын үлгэр”-ийн дүрүүдийг авч үзвэл, гол баатар нь Хар сандал баатар бөгөөд энэ бол монголын бөө мөргөлийн зүүний тэнгэр Хадаргаан хар боомон тэнгэрийн хувилгаан байдаг. Энэ тэнгэрийн дуудлагад

...Хүний махан хүнтэй

Хүрэл чулуун зүрхтэй гэж гардаг.

Энэ тэнгэр бол халхын “Хөгшин луу мэргэн хаан” туульд Бурхан багшийн гол дайсан, аварга их мангас болж гардаг. Хар сандал баатар бол Алтангалав Сандал хааны улсын тэргүүн баатар болоод Хар баатар цолыг олсон. Харин цагаан царайт Цагаан сандал баатар нь үлгэрийг өвлөн тээгч Б.Чунраа гуайн тайлбарлаж өгснөөр бол таван хошуу малын эзэн сүлд тэнгэр болдог. Тиймдээ ч тэнгэртээ буцалгүй газарт үлдсэн гэж гардаг. Түвдэннимаа Осормаа бол охин тэнгэр боловч төмрийн дархны эзэн тул бусад эмс шиг үйл үртэс оёдоггүй, үргэлж төмөр нүдэж, дарх хийж суудаг гэж гардаг.

Домгийн хэрэг явдлууд нь Хар баатрын мангастай хийсэн тэмцэл болоод Алтангалав Сандал хаанаа ураглуулсан түүхээр холбогдоно. Алтангалав Сандал хаан нь Шавдай, Нявдай, Лувсан, Хастараа дөрвөн түшмэлтэйгээ тэнгэр тулам улаан галаар хүрээлсэн гал хот мандалдаа амьдарна. Алтангалав Сандалт хаан нэг удаа ан хийж яваад, Хар баатрын дүү Түвдэннимаа Осормаатай тааралдан, ангийн олзоо булаалдан танилцаж, Алтан Дуулга баянаас эд эрдэнэс, энэ ертөнцийн хамгийн ховох есөн ес наян нэгэн юм амлан, охиныг нь гуйж авч ураглана. Хар баатар Алтангалав Сандалт хааны тэргүүн баатар болоод, жимс ургамал иддэг, жижиг биетэй Жан Шамбалын орны хааны охин Задангуй гүнжийг мангасаас булаан, хаандаа хатан буулгаж авч өгнө. Алтангалав Сандалт хааныг мангасын охин Галвин Сөөрий өөртөө эр болгохоор, удаа дараа хулгайлж авч явахад Хар баатар очиж буцаан авчирна. Хар баатар Суунаг цагаан мангасыг хүншүүлж, Алтангалав Сандалт хааны дэд баатар болгоно.

Мангаст хувилж төрсөн тэнгэрүүд гэвэл Суунаг цагаан, Шилэн галзуу баатар, Сам бурхан, түүний хүүхдүүд болно. Суунаг цагаан нь гучин зургаан тэнгэрийн түрүү / ахлаач/ Суунаг цагаан тэнгэр гэгч бөгөөд Эвэрт мангас Марву Осорын хүү болж төрнө. Хувилгаанаар мангаст хувилж төрөхдөө өөрийн эх мөнгөн толгойт Мөгөлмаа мангасыг

бариад идчихсэн гэж гардаг. Хар баатар түүнийг аргалж хүний омогт авчраад, хүний махаас гарган хүншүүлж, Алтангалав Сандал хааны дэд баатар болгодог. Шилэн галзуу баатар бол Галавын үлгэрт болохоор мангаст хувилж төрөөд мангасыг дараад буцсан нэгэн тэнгэр гэж гардаг. Энэ нь монголчуудын дунд түгээмэл дэлгэрсэн ураг хуримын туульд гардаг Хилэн галзуу баатар мөн бололтой. Халх хувилбарт Хилэн галзуу баатар, барга хувилбарын Шилэн галзуу баатар, үзэмчин хувилбарт Ажиг тэнэг баатар нэрээр гардаг. Энэ дашрамд өгүүлэхэд Цэрэн, Насантөмөр нарын цоорчдоос тэмдэглэсэн “Боди галав” үлгэрийг хэвлүүлсэн Самбалноров бидэнд *“Баруун талаараа арван найман галав, зүүн талаараа зургаан галав хэлдэг цоорчид байсан. Нэг галав нь нэг хааны үлгэр юм. Нэг Галавын үлгэрт нэг сайн баатар гарна. Бодигалавын үлгэрт Шилэн галзуу баатар гэж, Алтангалавын үлгэрт Асарцагаан Хайчин гэж баатар гарна”* гэж мэдээлсэн юм. Үүнээс үзэхэд, бидний судалж буй Галавын үлгэрийн бичвэр нь эртний аварга домог зүйн товч хураангуй хэлбэр байж мэдэх төдийгүй “Хилэн галзуу баатар” зэрэг бидний урьд нь ураг хуримын туульс гэж нэрлэж байсан зарим туульсыг Галавын үлгэртэй зэрэгцүүлж судалбал монгол домог зүйн цогцолбор шинж илүү тодрох юм байна гэсэн сонирхолтой таамаглал ч төрж байна.

Хүний мах иддэг аймшигт мангасын дүрүүдийн эхинд мангасын орны хааныг Лан-аа Ринжүү гэгч гарна. Энэ бол Ланга тивийн арван хүзүүт гэсэн нэр бөгөөд бидний мэдэхээр эртний Энэтхэгийн “Раамаяна” туулийн арван толгойт Рааван мангас юм. Үүнээс үзэхэд энэ бичвэрт дорно дахины олон үндэстний домог туульсын нөлөө их байна. Лан-аа Ринжүү мангас Гаарий Үнчог гэж хүү, Галвин Сөөрий гэж охинтой. Мангасын охин Галвин Сөөрий заарайж сэгсийсэн үстэй, зөрүү нүд, цоохор царайтай, үзэмжгүй муухай ч өөрийн нүүр царайг түрхэж нуун, Алтангалав Сандалт хааныг хүчээр өөртөө эр болгох гэж удаа дараа хулгайлахад Хар сандал баатар буцааж авчирч байдаг. Суунаг цагаан баатрыг тарүүлээд идүүлсэн мөнгөн толгойт Мөгөлмөө мангасын хань эвэрт мангас Марву Осорын Хар баатар буулган авч хөтчөө болгож байна.

Сам (Лхам) бурхан бол буддын шашны арван хангал догшин бурханы нэг боловч Галавын үлгэрт болохоор тэнгэрээс мангаст хувилж төрсөн ганц эмэгтэй баатар гэж гардаг. Сам мангасын эхнэр болоод хоёр хүү хувилгаж, нэг охин төрүүлсэн бөгөөд баруун зүүн хоёр сугаар гарсан хоёр хүү нь тэнгэрийн хувилгаан байж, умайгаас төрсөн охин нь мангас байдаг. Сам шинэ төрсөн охины толгойг нь тасдан, шөрмөсийг нь сугалж алаад, шөрмөсөөр нь дөрөөний сур, дөрвөн ганзагаа хийж тохоод явдаг. Энэ өгүүлэмж нь Бурхан шашны Балданлхам бурхны хөрөг зургийн өгүүлэмжтэй үндсэндээ таарах бөгөөд энэ аймшгийн дүр байдал, зан төрх нь мангасын хар хүчийг биедээ эзэмдэснээр тэднийг ялан дийлэх учир зорилготой уялдаж байдаг. Сам бурхны хоёр хүү Сэнгэ Донран (Арслан толгойт), Шүүсрэн Донран (Матар толгойт) гэдэг бол тэнгэрээс буулгасан есөн тэнгэрээс сүүлдэж буусан хоёр тэнгэр юм. Галавын үлгэрт Сам бурхны хүүхэд гэж гарч байгаа бол Лхам бурхны төвөд паянд хоёр дагуул болж гардаг. Сам бурхан хүүхдүүдтэйгээ мангасыг хүлж авчраад, цусан далайд дарсан ч тэнгэртээ буцалгүй мангасыг сахиж, газарт үлдсэн баатрууд гэж гардаг билээ. Шинжааны ойрдууд Сам гэдэг, буриад баргачууд Хам гэдэг, халимгууд охин тэнгэр гэдэг, халх монголчууд Лхам бурхан гэдэг энэ дүрийг дагасан домог монгол, төвөд болон төв Азийн ард түмний дунд аман хувилбараар маш өргөн тархсан байдаг. Лхам бурхны домог бол буддын синкретизмын хамгийн тод томруун жишээ болох бөгөөд энэ талаар тусгайд нь судлах шаардлагатай юм.

Бичвэр сүлэлдээний өвөрмөц хослол гэж хэлж болохоор энэхүү туурвилын төгсгөл хэсэгт тэнгэр бурхад газар дэлхийгээс буцахдаа газар дэлхий дээр үр хүүхдээ үлдээсэн нь Гэсэрийн гол баатрууд болсон тухай өгүүлдэг. Тэнгэр нар хүн иддэг аймшигт мангасыг дарахыг нь дарж, хүний махнаас гаргахыг нь гаргасаар газар дэлхийг цэвэрлэж дуусаад, тэнгэртээ буцаж дэвших нь дэвшээд, газар дэлхийд уул, ус, газрын эзэн болж үлдэх нь үлдэнэ. Гэхдээ Алтангалав Сандал хаан, Түвдэннимаа Осормаа нарын дундаас ирээдүйн

Гэсэрийн эцэг Сэнлон мэндэлсэн бол Алтангалав Сандал хаан, Задангуй гүнж нарын дундаас Гэсэрийн авга Чутан (Цотон) төрдөг. Мөн Алтангалав Сандалт хаан, Галвин Сөөрий мангас хоёрын дундаас Шарай голын гурван хаан төрдөг. Энэ угсаа гарлын домгийг шинжилж үзвэл, хоёр тэнгэрийн дундаас төрсөн нь хожим Гэсэрийн эцэг Сэнлон болсон, тэнгэр -хүн хоёрын дундаас төрсөн нь Гэсэрийн хорон санаат авга Цотон болсон, тэнгэр-мангас хоёрын дундаас төрсөн нь Шарай голын гурван хаан болсоныг харж болно. Тэрчлэн Алтангалав Сандалт хааны хүүхдүүдийг дагасан үйл явдлын гол шугам нь цаашид Гэсэрийн туужийн дотор үргэлжилж, Сам бурхныг дагасан нөгөө шугам нь монголчуудын Цагаан сарын домог, “Ханцуй савардан” бүжгийн зан үйлтэй очиж холбогдох нь тодорхой байна.

Хүснэгт 1.

	Домог зүйн ангилал	Галавын үлгэрийн дүрүүд	Гэсэрийн туужтай холбогдох нь
Дээд тив	Тэнгэр бурхад	1. Хан Хурмаст 2. Таван номын эзэн 3. Шагжамуни, түүний шавь нар 4. Бадмагата Анандын өөр нэр	
	Тэнгэрээс буулгасан 9 тэнгэр	1. Алтангалав Сандал хаан 2. Хар сандал баатар 3. Цагаан сандал баатар 4. Түвдэннимаа осормаа 5. Суунаг цагаан баатар 6. Шилэн галзуу баатар 7. Сам бурхан, түүний хүүхдүүд (Сэнгэ Донран, Шүүсрэн Донран)	
Дунд тив	Тэнгэрээс буулгасан уул, газар, усны эзэд	1. Хастараа 2. Шавдай 3. Нявдай 4. Лувсан	Сэнлүн- Тэнгэр нарын дундаас төрсөн
	Хүн	1. Алтан Дуулга баян 2. Нарангэрэл цогт хатан 3. Жамсрангомбо хаан 4. Задангуй гүнж	Цотон- Тэнгэр-хүн хоёрын дундаас төрсөн
			Шарай голын гурван хаан- Тэнгэр-мангас хоёрын дундаас төрсөн
Доод тив	Мангас	1. Лан-аа Ринжүү 2. Гаарий Үнчог 3. Галвин Сөөрий 4. Мангасын бөө 5. Марву осор 6. Мөнгөн толгойт Мөгөлмаа	

Б.Чунраагийн хэлсэн Галавын үлгэрийн дүрүүд

Б.Чунраа өвгөний хэлсэн Галавын үлгэрийг 1987 онд Оросын эрдэмтэн В.Э.Раднаев үзээд “Энэ бол маш өвөрмөц, хэмжээний хувьд үлэмж, бөө мөргөл ба буддын уламжлалын яг зааг дээр байгаа бүтээл бөгөөд өнөөдрийг хүртэл шинжлэх ухаанд мэдэгдээгүй байсан домог туулийн дүр, өгүүлэмжийг агуулсан байна” (1987:206) хэмээн тэмдэглэснийг энд дурдмаар байна. Үнэхээр Галавын үлгэрүүд нь хэмжээний хувьд үлэмж төдийгүй, бөө мөргөл ба буддын уламжлалын яг зааг дээр байгаа бүтээл байна. Тэнгэр бурхадын дүрүүдийн хоорондын холбоо хамаарал, захирах захирагдах харьцааны хувьд шинжлэн үзвэл, 1977 онд Б.Чунраа өвгөний хэлсэн Галавын үлгэрт Ханхурмаст нь Шагжамунидаа тушаал зарлиг буулгаж, Шагжамуни аварга мэлхийг харвасан тухай гардаг бол, Жалсан өвгөний хэлсэн хувилбарт эсрэгээр буюу Гэсэрийн туужид гардаг шиг Шагжамуни нь Хан хурмастад

зарлиг буулгаж байна. Энэ нь Галавын үлгэр бол анх үүсэхдээ бурханы шашны агуулгатай байгаагүй бөгөөд хүрээ хийдийн шашны сэхээлэг хүмүүс уугуул агуулгыг бурханы шашинд нийцүүлэн хувиргаснаар энэ уламжлал тэсэж үлдсэн бололтой гэсэн таамаглалыг төрүүлж байна. Гэсэрийн туужийн дэлгэрэлтэй харьцуулаад хэлбэл, магадгүй бурханы шашинд харш агуулгатай болохоороо “Галавын үлгэр” дэлгэрч чадалгүй, Гэсэрийн тууж нь илүү сайн түгэн дэлгэрсэн ч байж болох юм. Галавын үлгэрийн өгүүлэмжийн талаар Жалсан хуурч бидэнд хэлэхдээ “Бадамшамба бурхны галав гэж бий. Шамба бурхан чинь Хан хурмастын багш нь. Тэнгэрийн багш нь Бурхан шүү. Зааж өгөх нь багш, засаг явуулах нь тэнгэр гэдэг юм. Үзэхгүйгээр мэддэг билгийн нүдтэй, өнгөрөхгүйгээр мэддэг оюун цээжтэй гэж Бурханыг хэлдэг” гээд, цааш өгүүлэхдээ “Гурван жилдээ хүн бий болоод Шамба бурхантай яриа зоог хэлэлцэх болжээ. Хүнийг эхлээд нисэхээр бүтээжээ. Нисгэх гэтэл чулуун мөндөр буужээ. Хэд хэдэн эрэгтэй, эмэгтэй үхжээ. Сохор, догolon, тэгшгүй арвин гэнэ. Мөндөр бороо оржээ. Хар толгойтуудаа зөөж агуйд оруулжээ. Оруулаад дахиад амилжээ. Эргээд гурван жил амилжээ. Хугар хай бол хугархай гар хөлтэй, зэмдгээрээ амилжээ. Багш хос хосоороо эр эм болж амьдар, тэгвэл үржинэ гэж. Эмгүй эр хэд гарна, нисгэжээ. Эргэж хоёр шавь, сандлын хоёр шавь авчирна. Зулай хоёр мөрөөс нь гэрэл гарна. Тэр хүний хүн найман түм, найман зуу илүү насалж байж. Хэдэн зуун түмэн жил өнгөрч иржээ. Хүн арвиджээ. Хүн арвидсаар нутаг ховорджээ. Чадалтай нь чадалгүйгээ яллана. Дээрэнгүй болсоор гэрэлгүй болжээ. Хүний гэрэл хаагдаад, дөрвөн түм, дөрвөн зуу илүү наслах болж. Чиний гэрлээр амьдарч байна уу гэж үг байдаг нь эндээс ирсэн үг. Манай энд юу байна, тэр бүгд тэнгэрт байна. Алтан солонгот агуйд суужээ. Эрлэг, лус, дунд орчлон, тэнгэр дөрвөн орчлонг нэвт үзнэ. Өдөр харанхуй болж. Чи гэрэл гарга гэжээ. Очирваань бол мянган нүдтэй бурхан. Улаан тоост урваа хөрвөө орчлон гэж үг бий. Чандмань хумхыг аваад чи өмнө далайд очоод нэг бүл, хоёр бүл, гурав бүл гэжээ. Гурваас илүү бүлж болохгүй гэжээ. Чандмань хумхаас гэрэл гарна. Нэг бүлж, алтан хүү - наран мандаж, хав харанхуй байсан орчлон гэв гэгээн болжээ. Хоёр бүлж, хасан хүүхэн- саран гарчээ. Гурав бүлэхэд тэнгэрийн түмэн од гарч, хот мандаас хумх дүүрэн ногоон рашаан тунажээ. Од бол тэнгэрийн буянтны од гэнэ. Мартжээ. Дөрөв бүлвэл юу гардаг бол гээд бүлтэл мангасын мянган жил бясалгаад хэвтсэн нь дүүрээд, мангас год үсрээд гараад иржээ. Уулаас өндөр биетэй, хав харанхуй болж. Айчиж. Салхи шуурганд өмхий үнэр хамарт хадна. Мангасын салхи ваа. Очирваань шоож (цохиж). Нэг, хоёр, гурав, зургаа, долоо, найм, ес, арван найм шоожээ. Их галав арван найм шүү. Арван найман уул болоод бас л харанхуй. Дээш гарч Алтанхүүтэй уулзлаа. Алтанхүү инээнэ. Чи гурван тив тойроод мангасыг гүйцэхгүй гэж. Хасанхүүхэнд очиж. Чи байтугай, Шамба бурхан хөөж гүйцэхгүй гэж. Арван наймаа алдаад явуулчихаж, юу юм мэдэхгүй болж. Хүрээд очиж. Тэнгэрийн ёсоор золгож. Гурав бүл гэхэд чи юунд дөрөв бүлсэн юм гэж. Түмэн оны лаг шулам-мангасыг гаргачлаа чи. Одоо арван найман галав түүднэ. Арван найм хагарчихаж гэж. Ингээд мангас гэгч, ягчидын ягча тив гэж гарчээ. Энэ галавын үлгэр гэдэг бол мангас тэнгэр хоёрын тулаан юм шүү, хүний явдал биш ээ” гэж ярьсан юм.

Галавын үлгэр дэх мангас махчны дүр, өгүүлэмжийн домог зүйн үүрэг бол хүний махаар хүнсэлж байсан эрт цагийн хүний ой дурсамж хийгээд айдас хирдхийллээр дамжуулж, энэхүү соёл иргэншлийн дэвшлийн үнэ цэнийг хойч үед сануулсан байна. Тухайлбал, энэ домогт мангас гэдэг бол хүний мах иддэг амьтан бөгөөд хүний мах идэх л юм бол хэн ч ялгаагүй мангас болно гэдгийг Алтангалав Сандал хаан мангасын оронд хулгайлагдаж очоод байхдаа хүний мах идсэнээр, бүх биеэр нь үс ургаж, мангас болсон байсан өгүүлэмжээр үзүүлсэн байна. Тус домгийн өөр нэгэн дэвшилтэт санаа нь нэгэнт мангас болсон бол тэр чигээрээ дуусдаггүй, өөрийгөө хичээн хүслээ барьж, хүний мах идэхээ боливол эргэн хүн болно гэдгийг сургадаг. Тухайлбал, Хар баатар Суунаг цагаан мангасыг хүний махнаас гаргаж, Алтангалав Сандал хааны дэд баатар болгодог, эм мангас Галвин Сөөрий ч хүний мах идэхгүй гэсэн тангараг өргөж, хүний махнаас гардаг өгүүлэмжүүд нь үүнийг илтгэнэ.

1977 онд “Галавын үлгэр”-ийг анх мэдээлсэн Б.Чунраа өвгөний дурсамжаас үзэхэд хуучин цагт энэ нь шүлэглэсэн хэлбэртэй байгаад морин хуурын аялгуунд хэлдэг байсан ба тэр дундаа мангастай тулалдаж мангасын толгойг авах хэсгийг өгүүлэхэд зул барьдаг байсан ажээ. 2019 оны 8 сарын 30-ны өдөр Тунлио хотод Жалсан гуайн гэрт зочлон, Галавын үлгэрээс хэлүүлэхэд мөн л тэрээр зул барин, цоор (хутга тэвхэдсэн мангас толгойтой хуур) хөгжмөөр цоордон хэлж байсан билээ. Цоор хөгжимд хутга тэвхэдсэний учрыг асуухад тэрээр мангасыг дарах хатуу үйлийн учир бэлгэдлийг тайлбарлаад, “Бүрэнцугла гурван галав яриад эмнэлэгт нас барахдаа *“Арван найман галав хэлнэ гэдэг бол арван найман тамыг туулах юм шүү”* гэж хэлж байсан тухай онцлон дурссан билээ.

Галавын үлгэр гэдэг нь Лионин мужийн Сүргийн хошуу, Хүрээ хошуунд илүү хамаатай соёл байна. Галавын үлгэрийг 1977 онд мэдээлсэн Б.Чунраа гуай мөн Сүрэг хошууны хүн байсан. Жалсан цоорчийн маш итгэл үнэмшилтэйгээр бидэнд тайлбарласнаар *“Мангастай тулаан хийсэн газар нь энэ Хүрээ хошуунд бий. Айх шарын даваа бол Галбин шарын чухам тулаан хийсэн газар, есөн зуун ерэн есөн (999) гуу сувагтай газар юм гэдэг. Хамаг сүүлд мангасыг Балданлхам бууж ирж дарна. Тэр газар нь Эхин тэнгэрийн сүлд гэдэг”* гэсэн билээ. Энэ талаар хожим нарийвчлан судлах болно.

“Галавын үлгэр” хэмээх энэ өвөрмөц бичвэр дотор сүлэлдэн байгаа олон янз хам бичвэрүүд хийгээд монголын, төвөдийн, энэтхэгийн, ерөөс Төв Азийн олон домог, туульсын олон дүр, өгүүлэмжүүд нь энэ бичвэрийн төрөл зүйлийг тогтооход бэрхшээл үүсгэдэг. Тухайлбал, С.Ю.Неклюдов “Туульсын найруулга нь эвдэрсэн ч гэсэн энэ бол сюжетын хувьд гарцаагүй монгол баатарлаг туульсын шинжийг агуулж байна” гэж үзсэн байдаг. Сэдэв, өгүүлэгдэхүүний тухайд нийт монголын баатарлаг туулийн гол сэдэв, өгүүлэгдэхүүн болох мангасыг дарсан сэдэв, өгүүлэгдэхүүн байгаа ч энэ нь туульс гэж нотлоход хангалттай биш юм. Миний бодлоор энэхүү Галавын үлгэр гэдэг бол мангас махчны домог зүй байна. Онолын хувьд домог (myth), тууль (epic) гэдэг хоёр төрөл зүйлийг ялган таних анхны шалгуур нь гол баатар нь тэнгэр бурхан байна уу, хүн байна уу гэдэгт, удаах шалгуур нь хэний шийдвэрийг гаргаж, хүчийг эзэмшиж, хэн ялалтыг авчирч байгаад оршино. Домогт бол хүний амьдрал, хувь заяаг ямагт тэнгэр нар соёрхож, тэнгэр нарын шийдвэр, оролцоотойгоор үйл хэрэг өрнөж бүтэж байгаа гэж үзүүлдэг бол баатарлаг туульст хүнийг дүрслэгдэхүүнийхээ төвд авчирч, туульсын баатар нь тэнгэр нарын эрхшээлийг үгүйсгэж, хүний хүчин чадлыг батлан тунхаглахын төлөө тэмцэж байдаг. Бидний судалж буй “Галавын үлгэр”-т мангасыг дарсан баатарлаг үйл хэргийг үзүүлэхдээ хүний хүчин чадлыг огт батлаагүй, харин ч эсрэгээр дээд тэнгэр нар болоод бурхадын шийдвэр, хүч, оролцоог тунхаглаж, хүмүүс нь тэнгэр бурхадын шийдвэр эрхшээл доор байх тул бид энэ туурвилыг цэвэр домог зүйн бүтээл гэж үзэж байна.

Дүгнэлт

1. “Галавын үлгэр”-т Төвөд, Энэтхэг, Төв Азийн домог туульсын нөлөө тусгал багагүй байгаа ч монгол бөөгийн хар цагаан тэнгэрийн дүрүүд болон матар мэлхийг харвасан тухай, газар дэлхий биежин үүссэн тухай өгүүлэмжүүд нь монгол домог зүйн цогцолбор шинжийг баталж байна.
2. “Галавын үлгэр” хэмээх энэ туурвилд сүлэлдэн байгаа олон янзын хам сэдэв, дүр, өгүүлэмжүүд нь төрөл зүйлийг тодорхой тогтооход бэрхшээл үүсгэдэг ч дүрийн онолын үүднээс шинжилбэл хүний хүчин чадлыг бус, эсрэгээр дээд тэнгэр нарын шийдвэр, хүч, оролцоог тунхаглан байгаа нь тус бүтээлийн домог зүйн шинжийг баталж байна.
3. “Галавын үлгэр” дэх мангас махчны дүр, өгүүлэмж нь хүн хүнээ барьж хүнсэлж байсан эрт цагийн айдас хирдхийллийн ой дурсамж болох бөгөөд хүний махаас татгалзаж чадсан хүн төрөлхтний соёл иргэншлийн дэвшлийн үнэ цэнийг хойч үедээ таниулах домог зүйн соёлын үүрэг ч тодорхой байна.

4. “Галавын үлгэр”-ийн төгсгөл дэх Гэсэрийн туужтай шууд холбогдож буй угсаа гарлын домгийг шинжилбэл, тэнгэр нарын дундаас төрсөн хөвүүн нь хожим Гэсэрийн эцэг Сэнлон болоод, тэнгэр - хүн хоёрын дундаас төрсөн хөвүүн нь Гэсэрийн хорон санаат авга Цотон болж, тэнгэр- мангас хоёрын дундаас төрсөн хөвүүд нь Шарай голын гурван хаан болж байх ба үүгээрээ тус бичвэр нь “Гэсэрийн тууж”-ийн өмнөх домог зүй болж холбогдож байна.

CHARACTERS AND MOTIFS OF “STORY OF THE GALAV” OF THE QORCHINS

A Mongolian mythological text of the “*Story of the Galav*” was taken down by S.Dulam in Ulaanbaatar in May 1977, from a 73 years old Bayaryn Chunraa, who was moved from Qorchin Mongol to Ulaanbaatar in the 1940s. In 1983, S.Dulam circulated it in scientific circles with J.Vacek in Charles University Prague. Among a great variety of motifs, which construct main mythic and epical characters in the texts of the “*Story of the Galav*” of Mongolian, Tibetan, Indian and Central Asian, make it complicated to define its genre. The transmitters of this work considered it as a story tale, but the scholars who studied the work used a binary term of mythic-epic.

According to theoretical point of view, the author considers that the story has mythic characters with power, decision and interference of the heaven, not human power. Specifically, it is defined as mythology of monsters/creatures that remind the future generation about civilization’s value and progress through the fear of the ancient recalls of the human beings who were eaten human flesh. By analyzing the ending of the “*Story of the Galav*”, the myth of origin is directly related to Geser epic – Senlon born from the heavens and the sun became the father of Geser, Tsoton, uncle of Geser came from the heaven deity-human and the sons of Sharai golyn three kings were born from heaven deity-monster, – this is regarded as a beginning of the myth of “Geser epic”.

Номзүй

- Dulam S., Vacek J.** 1983. *A Mongolian Mythological Text*. (Studia orientalia pragensia, XII). Ed., by M.Kubesova, Charles University Prague.
- Dulam S., Vacek J.** 2013. *A Mongolian Mythological Text*. УБ.
- Heissig W.** 1983. *Erzahlstoffe Rezipienter Mongolischer heldendichtung*. Teil I, Asiatische Forschungen, Bd. 100. Otto Harrassowitz –Wiesbaden.
- Неклюдов С.Ю.** 1999. *Мифо-эпический синтез в монгольском фольклоре: “Сказание о Кальне”*. Фольклор и мифология Востока в сравнительно-типологическом освещении. Ред. Н.Р.Лидова, Н.И.Никулин, М., Наследие, стр. 193-212.